



## ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2020 оны 04 сарын 28 өдөр

Дугаар 4478

Арвайхээр

### Хөрөнгө зарцуулах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн онцгой комиссын 9 дүгээр хурлын тэмдэглэлийг үндэслэн Коронавируст (COVID-19) цартахлын халдвараас урьдчилан сэргийлэх зорилгоор Арвайхээр сумын гэр хорооллын 7069 айлын нүхэн жорлонд ариутгал халдвартгүйжүүлэлт хийх зардалд 25,000,000 (хорин таван сая) төгрөгийг зарцуулсугай.

2. Дээрх зардлыг гамшгаас хамгаалах, эрсдэлийг бууруулах арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Д.Нэмэхбаяр)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Г.ГАНБОЛД



011100381